



ХААБ
ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ

2021 жилийн тайлан



АГУУЛГА


ОРШИЛ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ
АРИЛЖАА, ТӨЛБӨР ТООЦОО
ТӨЛБӨР ТООЦОО, ГИШҮҮНЧЛЭЛ
ЦАХИМ ХӨГЖҮҮЛЭЛТ
АГУУЛАХЫН ИТГЭМЖЛЭЛ
СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ
ЗАХИРГАА, УДИРДЛАГА
АУДИТ
ХҮНИЙ НӨӨЦ
НИЙГМИЙН АСУУДАЛ
АРХИВ, АЛБАН ХЭРЭГ
ХӨТЛӨЛТ
ХУВЬЦАА ЭЗЭМЧИГЧДИЙН
ХУРАЛ

ДҮГНЭЛТ





ОРШИЛ



ОРШИЛ


Хөдөө аж ахуйн бирж ХХК нь 2021 онд Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын бараа, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах, цэвэрлэх, биржээр арилжих оновчтой тогтолцоог бий болгох замаар малчид, хоршоодын оролцоог нэмэгдүүлэх, дотоодын үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангах, экспортын орлогыг өсгөх зорилгыг дэвшүүлэн ажиллалаа.

Хөдөө аж ахуйн бирж ХХК нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс батлагдсан бүтэц орон тооны дагуу 5 нэгж 43 ажилтны бүрэлдэхүүнтэй биржийн үйл ажиллагаатай холбоотой хууль, дүрэм, журам, Засгийн газрын хөтөлбөр, тогтоол, Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамны бодлого, албан даалгавар, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллалаа.

Дээрх бодлого шийдвэрийн хүрээнд 2021 онд дараах онцлох ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Бирж нь 2022-2026 оны дунд хугацааны стратегээ тодорхойлж ТУЗ-өөр батлуулсан.

Блокчейн технологи дээр суурилсан арилжаа, төлбөр тооцооны иж бүрэн системтэй болсон.




Биржээр хүнсний буудайн арилжааг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангасан.

Цахим хөдөө аж ахуйг бий болгох зорилгын хүрээнд 21 аймгийн 309 суманд биржийн итгэмжлэгдсэн агуулахыг байгуулах талаар мэдээллийг хүргүүлж, бүх сумдын агуулахын судалгааг хийж, 76 агуулахтай түр гэрээ байгуулсан.

Түүхий эдийн нөөц, зах зээлийн өнөөгийн байдал, тээвэр, загвар хоршоо зэрэг олон сэдвээр суурь судалгааг хийсэн.

Компани жилийн эцсийн санхүүгийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 6098,1 сая төгрөгийн орлого, 2571,2 сая төгрөгийн зардалтай, 3526,9 сая төгрөгийн ашигтай ажилласан.

Корона вируст халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах тухай Улсын онцгой комисс, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор компаний дотоод ажил, ажилтны ажил үүргийг дотооддоо зохион байгуулан ажлын байранд болон цахимаар ажил үйлчилгээгээ тухай бүр гүйцэтгэсэн байна.





ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



• **Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн
Гүйцэтгэх захирал Ж. Осоржамаа**


ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь Монгол Улсын Их хурлын 2011 оны 6 дугаар сарын 02-ны өдөр батлагдсан Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн дагуу хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн сайдын баталсан жагсаалтад орсон бараа, түүхий эдийг экспортод гаргахын өмнө биржийн арилжааг хуулиар тогтоосон журмын дагуу зохион байгуулах, түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндсэн чиг үүрэг бүхий төрийн өмчит компани юм.

Компанийн хувьцаа эзэмшигч болох Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй үйл ажиллагааг уялдуулах, биржээр арилжих бараа, түүхий эдийн онцлогоос хамаарч зах зээл хөгжүүлэх чиглэлээр судалгаа хийх, компанийн үйл ажиллагааг боловсронгуй болгох Дунд хугацааны /2022-2026/ стратегийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулан батлуулж, бизнес төлөвлөгөөний хүрээнд шинээр нэвтрүүлэх бараа, түүхий эдийн судалгаа хийх, хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, бусад орны сайн туршлагаас тогтмол судлах, компанийн гадаад харилцаа болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, биржийн арилжааны зуучлагч брокерын компанийг арилжаанд оролцох нөхцөл боломжоор хангах зэрэг ажлуудад анхаарал хандуулан ажиллаж байна.

Цаашид гишүүнчлэлийн оновчтой бодлого тодорхойлон хэрэгжүүлж байнгын болон байнгын бус гишүүдийн тоог нэмэгдүүлэх, стандартын шаардлага хангасан агуулах, тээврийн байгууллага, лабораторид итгэмжлэл олгох харилцааг зохион байгуулах, цахим арилжааны дэд системийг хөгжүүлэх, нэвтрүүлэх, хэвийн үйл ажиллагааг нь хангах чиглэлээр төлөвлөсөн ажлуудыг гүйцэтгэнэ.

Хөдөө аж ахуйн биржтэй хамтран ажилладаг бизнесийн байгууллагууд, биржийн гишүүн брокерын компаниуд, аймаг сумдын удирдлагууд, хоршоод, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэгч малчид, хоршоод та бүхэндээ ажлын амжилт хүсье.




АРИЛЖАА,
ТӨЛБӨР ТООЦОО



АРИЛЖАА, ТӨЛБӨР ТООЦОО


Хөдөө аж ахуйн бирж ХХК нь 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар нийт 129 удаагийн арилжаа зохион байгуулж, 958 хэлцлээр 5475 тонн ноолуур, 5352.4 тонн хонины ноос, 473.3 тонн тэмээний ноос, 2323.4 тонн ямааны завод ноос, 800 тонн тосны ургамал /рапс/, 80 тонн хонины завод ноос, 30000 ширхэг ямааны арьс тус тус арилжиж, нийт 725.0 тэрбум төгрөгийн гүйлгээ хийлээ.

Зохион байгуулсан арилжааны тоо (2016-2021, улирлаар)




Бараа түүхий эдийн бэлтгэн, нийлүүлэлтээс хамааралтайгаар I, IV улиралд арилжааны тоо багасч харин II, III улиралд арилжаа идэвхждэг болно.

Арилжааны үнийн дүн (тэрбум ₮)




2021 онд гадаад валютын ханшийн хэлбэлзэл, дэлхийн нийтийг хамарсан цар тахлын улмаас дотоодын үйлдвэр, экспортлогч аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсон хэдий ч Биржийн арилжааны шимтгэлийн орлогын 90-95 хувийг дангаар бүрдүүлдэг голлох түүхий эд болох ноолуурын ханш тогтвортой байснаар энэ оны арилжааны нийт дүн өмнөх онтой харьцуулахад 48.3 хувиар өссөн байна.

Арилжааны үнийн дүн (сараар, тэрбум ₮)



Арилжааны үнийн дүн, хэмжээ (барааны бүлгээр)



Хүнсний буудайг арилжих, бэлтгэл хангах чиглэлээр:



"Хүнсний буудайн техникийн тодорхойлолт"-ыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй техникийн баримт бичиг болон урамшууллын кодчилолтой нийцүүлэн шинэчлэн боловсруулж Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулсан. Хүнсний буудайг хүлээн авахад хяналт тавих, дээж авч шинжилгээ хийн, хүнсний буудайн зэрэглэл тогтоох лаборант ажиллуулах зарын дагуу 44 лаборантын анкетыг хүлээн авч, тэдгээрийг лаборантуудыг чадавхижуулах сургалт зохион байгуулахаар ХААИС-ийн Мал эмнэлэг, биотехнологи, Агроэкологийн сургууль, Ургамал хамгаалал, эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран хийхээр гэрээ байгуулсан боловч ХХААХҮЯ-наас уг ажлыг хойшлуулах чиглэл өгсөн. Харин "Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль"-д төсвийн худалдан авалтыг биржээр хийнэ гэж заасны дагуу 2022 онд буудайн арилжааг биржээр хийх шаардлагатай байна.

Хүнсний буудайн чанарын шинжилгээ хийдэг лабораторийн хүчин чадал, чадамжийн судалгаа гарган, дотоодын лаборатори бүхий 19 аж ахуйн нэгжид биржийн итгэмжлэлд хамрагдан хамтран ажиллах хүсэлтийг хүргүүлж, 16 лабораторийг биржийн итгэмжлэлд хамруулан аж ахуйн нэгж, бирж, лабораторийн ажилтантай гурвалсан гэрээ байгуулж итгэмжлэгдсэн агуулахад хүлээн авсан хүнсний буудайн бүртгэлжүүлж ажилласан.

Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан хүнсний буудайн арилжааг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Хөдөө аж ахуйг дэмжих сан болон гурилын үйлдвэрийн агуулахуудын байршлыг газрын зураг дээр харуулсан график зураглал, арилжааны зураглалыг гаргав.



Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн суманд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, газар тариалан эрхлэгчид болон гурилын үйлдвэрүүд, брокерын компанийн төлөөлөл болох 88 иргэн, аж ахуйн нэгжийг оролцуулан 2021 оны 7 дугаар сарын 29-ний өдрөөс 8 дугаар сарын 01-ний хооронд Биржийн үйл ажиллагааг танилцуулан, хүнсний буудайн туршилтын арилжааг амжилттай зохион байгуулав. Биржээр хүнсний буудай арилжих түр журам, харилцагчдын хооронд байгуулах Худалдах, худалдан авах гэрээний загвар төслийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлууллаа.

Хөдөө аж ахуйг дэмжих сан болон гурилын үйлдвэрүүдийн агуулахын багтаамж, хүчин чадлын талаар хийсэн судалгаанаас харахад улсын хэмжээнд нийт 531,600 тонн буудай хадгалах 34 агуулах байгаагаас 325,000 тоннын багтаамжтай, лаборатори бүхий 23 агуулахтай байна.

Тариалан эрхлэгчид болон гурилын үйлдвэрүүдэд Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааг 6 удаагийн цахим уулзалтаар 124 тариаланчидтай, мөн газар тариалангийн бүс нутгуудаар явж 12 аймгийн 17 сумын 200 гаруй тариаланчидтай буюу нийт 350 орчим тариаланчидтай уулзалт хийж, сургалт зохион байгуулсан. Увс, Сэлэнгэ, Дархан, Эрдэнэт, Төв, Өвөрхангай, Хэнтий, Дорнод аймгийн 18 агуулах, гурилын үйлдвэрийн мэргэжилтнүүдэд программ ашиглалтын сургалт орж бэлтгэл ажлыг ханган ажилласан.



ХААБ
ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ

ТӨЛБӨР ТООЦОО, ГИШҮҮНЧЛЭЛ

ТӨЛБӨР ТООЦОО, ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Биржийн байнгын гишүүн оролцогчид клирингийн эрх авснаар баталгаат дэнчин, барьцаа хөрөнгө байршуулан өөрийн харилцагчдын гэрээний төлбөр тооцоог гүйцэтгэх боломжтой, клирингийн бус гишүүд баталгаат болон анхдагч дэнчин байршуулан арилжаанд орох бөгөөд арилжаанд оролцогчид гэрээний үүргээ биелүүлсэн, биржид ямар нэгэн өр төлбөргүй тохиолдолд тухайн дэнчин, барьцааг буцаан шилжүүлдэг. Энэхүү чиг үүргийн хүрээнд 2021 онд нийт 958 хэлцлийн 725 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийгдэн, төлбөр тооцоог хийж гүйцэтгэсэн. Өдрийн дундаж гүйлгээ 5,8 тэрбум төгрөг байв.

Нийт барьцаа болон дэнчингийн гүйлгээ 2021 онд 84,9 тэрбум төгрөг, өдрийн дундаж барьцаа болон дэнчингийн үлдэгдэл 0,7 тэрбум төгрөг байлаа.

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, Биржийн үйл ажиллагааны ерөнхий журамд заасан зохицуулалтын дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан 8 хуулийн этгээдээс Биржтэй Гишүүнчлэлийн гэрээ байгуулсан 6 брокерын компани арилжаанд идэвхитэй оролцож байна. Мөн хууль тогтоомжид заасны дагуу хоршоо байнгын бус гишүүнээр арилжаанд оролцож болох тул тайлант хугацаанд “Өндөр сант тахилга”, “Хөв дэлгэр” хоршоодыг байнгын бус гишүүнээр бүртгэгдэж гишүүнчлэлийн гэрээ байгуулаад байна.

2021 оны Биржийн арилжаанд 6 брокерын компаниар зуучлуулан 54 харилцагч оролцсон байна.

Тусгай зөвшөөрөл бүхий байнгын гишүүд нь давхардсан тоогоор нийт 124 удаагийн арилжаанд орсон байна. Энэ хугацаанд “Алтаншагай импекс” ХХК, “Хаан Тэлмэн” ХХК, “Ханбүргэд Хэнтий” ХХК зэрэг брокерын компаниуд хамгийн өндөр дүнтэй буюу 145-294 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийсэн байна.

Гишүүн брокерууд:

Байнгын гишүүн


Хан бүргэд хэнтий ХХК
Алтан шагай импекс ХХК
Хаан тэлмэн ХХК
Суварга алтай констракшн ХХК
Бадар хундага оргил ХХК
Цэц инвест ХХК

Байнгын бус гишүүн


Хөв дэлгэр хоршоо
Өндөр сант тахилга


Байнгын болон байнгын бус гишүүн оролцогчдын тоог нэмэгдүүлэх, шинээр элсүүлэхтэй холбоотой бүртгэлжүүлэлтийг хийх ажлын хүрээнд биржийн тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн “Грийнмэйд ланд” ХХК, “Алтай эко систем” ХХК зэрэг компаниудын баримт бичгийг хүлээн авч, анхан шатны дүгнэлтийг гаргалаа.

Байнгын гишүүн брокерын компаниудын үйл ажиллагаанд биржээс тавьсан шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхэд хяналт тавих зорилгоор 2021 оны 12 дугаар сарын 01-03-ны өдрүүдэд хяналт хийхээр төлөвлөсөн ч брокерын компаниуд цар тахлын нөхцөл байдлын улмаас үйл ажиллагаа тогтвортой бус байгаа тул хяналтыг хойшлуулах талаар ирүүлсэн хүсэлтийг харгалзан 2022 оны 2 дугаар сард хийхээр төлөвлөөд байна.



ЦАХИМ ХӨГЖҮҮЛЭЛТ





ЦАХИМ ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Блокчейн технологид суурилсан арилжаа, төлбөр тооцооны иж бүрэн системийн нэмэлт хөгжүүлэлтийн ажлын хүрээнд 5 нэгжийн 15 ажилтны бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрөөс 2 дугаар сарын 09-ний хооронд системийн 12 модуль дээр 113 техникийн даалгавар боловсруулан гүйцэтгэгч “Айтүүлс” ХК-д өгсөн.

Туршилтын арилжааг 69 удаа явуулж, арилжааны бүтэн циклийн үед гарч буй алдааг тухай бүр “Айтүүлс” ХК-д мэдэгдэн засварлах ажлыг гүйцэтгүүллээ.

Төсвийн урамшууллын системтэй өгөгдөл солилцох, хөгжүүлэлтийн ажлын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Төсвийн урамшууллын систем, “Айтүүлс” ХК-ийн төлөөлөлтэй хамтран цахим хурал хийж, цаашид хийгдэх ажлуудыг харилцан тохиролцож өгөгдөл солилцох гэрээг байгуулав. Хүнсний буудайг биржээр арилжих ажил хойшилсонтой холбоотойгоор уг хөгжүүлэлтийн ажил хүлээгдэж байна.

Блокчейн технологид суурилсан арилжаа, төлбөр тооцооны иж бүрэн системийн нэмэлт хөгжүүлэлтийн ажлын хүрээнд Гүйцэтгэх захирлын тушаалаар нэмэлт ажлын даалгаврын биелэлтийг шалгах ажлын хэсэг байгуулагдан 25 удаагийн туршилтын арилжааг 7 хүний бүрэлдэхүүнтэй хийж, нэмэлт ажлын 109 даалгаврыг хийж, 4 ажил нь хийгдэхээр хүлээгдэж байна.

Банкны системтэй холбоотойгоор Хаан банктай “Корпорэйт гэйтвэй үйлчилгээний хамтран ажиллах гэрээ”-г 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр байгуулж, гэрээтэй холбоотой хөгжүүлэлтийн ажлыг “Айтүүлс” ХК-ийн зүгээс эхлүүлэхээр тохиролцсон.

2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрөөс 1 дүгээр сарын 22-ны хооронд Тагнуулын ерөнхий газрын дэргэдэх Мэдээллийн аюулгүй байдлын газраар “Системийн аюулгүй байдлын аудит” хийлгэж, тайланг 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр хүлээн авсан.


Уг тайланд системийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай 15 зөвлөмж ирүүлснийг гүйцэтгэгч “Айтүүлс” ХК-д хүргүүлж, системд өөрчлөлт хийлгүүлэв.

“Ногоон алт-малын эрүүл мэнд” төслөөс санхүүжүүлсэн Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо ТББ-ын оюуны өмчит “Хариуцлагатай нүүдэлчин” системийн агуулахын модулийг хүлээж авч, хөгжүүлэх гэрээ байгуулсан. Гэрээг хэрэгжүүлэх зардлыг Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслөөс санхүүжүүлэх боломжтойг илэрхийлээд байна.


Хөдөө аж ахуйн биржийн түүхий эд бэлтгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох, жишиг сум байгуулах ажлын хүрээнд Хэнтий аймгийн Баян-Овоо сумын жишиг хоршооны агуулахад ашиглагдах RFID уншигч төхөөрөмж болон RFID tag-ийг худалдан авч, программын хөгжүүлэлтийг хийж бэлтгэл ажлын хангасан.



АГУУЛАХЫН ИТГЭМЖЛЭЛ




АГУУЛАХЫН ИТГЭМЖЛЭЛИЙН ТАЛААР



Хөдөө аж ахуйн биржийн 17 итгэмжлэгдсэн агуулахуудад хадгалагдаж буй бараа түүхий эдийн нөөц, нэр төрөл, тоо хэмжээ тохирч буй эсэхэд барааны шинжээч нар 8 удаа биечлэн хяналт хийж, фото зургаар баримтжуулан дүнг "Агуулахын нөөцийн мэдээлэл" маягтад оруулж Гүйцэтгэх захиралд танилцуулсан бөгөөд тус шалгалтаар ямар нэгэн зөрчил илрээгүй.

Хөдөө аж ахуйн салбарт хийгдэж буй "Цахим хөдөө аж ахуй" зорилтын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хөдөө аж ахуйн бирж, Мал эмнэлгийн ерөнхий газар хамтран малын түүхий эдийн чанар, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, малын гаралтай түүхий эдийн зөв зохистой бэлтгэлийг бий болгох, анхан шатны тордолт, чанарын хамгаалалт хийх, мөшгөх тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор 21 аймаг 309 суманд биржийн итгэмжлэгдсэн агуулахыг бий болгох зорилгоор Гүйцэтгэх захирлын 2021 оны 5 дугаар 06-ний А/24 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажиллалаа. Тус ажлын хэсэг 21 аймгийн бүх сумдын Засаг дарга болон Хөдөө аж ахуйн тасгийн дарга нартай холбогдож биржийн итгэмжлэл болон итгэмжлэгдсэн агуулахын мэдээлэл хүргүүлж ажилласны үр дүнд жилийн эцсийн байдлаар 15 аймгийн 63 сумын 50 хоршоо, 17 аж ахуй нэгж, 9 иргэний нийт 76 түүхий эдийн агуулахтай итгэмжлэлийн гэрээ байгуулаад байна.

Мөн 19 аймгийн 92 сумдаас ирүүлсэн Хөдөө аж ахуйн биржийн түүхий эдийн агуулахын итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг хангах агуулах байхгүй болохыг тодорхойлсон албан бичиг ирүүлснийг хянаж бүртгэлжүүлсэн



Хүнсний буудай биржээр арилжихтай холбоотой “Хамтран ажиллах санал хүргүүлэх” тухай албан тоотыг Хөдөө аж ахуйг дэмжих сангийн харъяа 5 салбар агуулахууд болон аж ахуйн нэгж, гурилын үйлдвэрийн дэргэдэх хүнсний буудайн агуулах, лабораториудад “Сорилтын лабораторид тавигдах итгэмжлэлийн шалгуур үзүүлэлт”, “Итгэмжлэлийн журам”-ын хамт хүргүүлэн, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласны үр дүнд үр тарианы 19 агуулах, 16 лабораторийг биржийн итгэмжлэлд хамруулан, итгэмжлэлийн гэрчилгээ олгож хаягжуулан, хариуцсан мэргэжилтнүүдтэй гурвалсан гэрээ байгуулан ажиллаж байна.

Үр тарианы 18, түүхий эдийн 17 итгэмжлэгдсэн агуулахын мэдээллийг “cloud.msc.mn” блокчейн технологид суурилсан арилжаа, төлбөр тооцооны шинэ програмын ложистикийн удирдлагын системд бүртгэлжүүлсэн. Итгэмжлэлийн гэрээний хугацаа дууссан 11 агуулахын итгэмжлэлийн гэрээг сунгаж, шинээр “Файнноос” ХХК-ийн агуулахыг итгэмжлэн итгэмжлэлийн гэрээ байгуулсан.

“Дарханы арьс ширний цогцолбор” ХХК-тай агентын гэрээ байгуулсан 49 хоршоо, аж ахуйн нэгжүүдэд биржийн итгэмжлэл олгох, шалгуур үзүүлэлтийн мэдээллийг цахимаар хүргүүлж, утсаар удаа дараа холбогдож ажилласны үр дүнд 2 хоршооны агуулахад Биржийн итгэмжлэл олгож, 10 хоршооны агуулахын бичиг баримтыг хүлээн авч итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг хангуулахаар зөвөлгөө өгч ажиллаж байна.



СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ





СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

Биржийн дунд хугацааны /2022-2026/ стратегийн төлөвлөгөөг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор батлуулав.

Биржийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, мэдээ мэдээллээр хангах, брендинг хийх зорилго бүхий биржийн 2022 оны Маркетингийн төлөвлөгөөг боловсруулав. Мөн компанийн судалгааны төлөвлөгөөг боловсруулж, түүнээс 2022 онд хийгдэх судалгааны болон үйл ажиллагааны төлөвлөгөөг нарийвчлан гаргав.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хүнсний буудайн зах зээлийн багтаамж, дотоодын тариалалтын талаар болон буудайг тус улсын таваарын бирж дээр арилжиж байгаа нөхцөл байдлын талаар судалгаа хийж, дотоодын буудайг биржээр дамжуулан худалдах боломжийн зураглал, хэрэгжүүлэх боломжийг урьдчилан тооцлоо.

Олон улсын биржүүдийн харьцуулалтын судалгааг Беларусийн универсал таваарын бирж, Этиопийн түүхий эдийн бирж, Энэтхэгийн түүхий эдийн бирж, Истанбулын таваарын бирж, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Жэнжоугийн таваарын бирж, Оросын Холбооны Улсын Үндэсний таваарын биржүүд дээр арилжааны үйл явц, бараа, түүхий эд зэргээр хийж гүйцэтгэв.

Адууны дэл, сүүлний зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, биржээр арилжих боломжийн талаар судалгааг хийж гүйцэтгэв.

“Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”, “Экспортыг дэмжих төсөл”-үүдтэй хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт, чанар стандартыг хангуулах, экспортын үйл ажиллагааг сайжруулах, арилжааны тогтолцоог боловсронгуй болгох хүрээнд хамтран ажиллах Санамж бичиг байгуулав.

Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын олон улсын судалгааны төвтэй хамтран ажиллах талаар санамж бичиг байгууллаа. санамж бичгийн хүрээнд 2022 онд хамтран ажиллах төлөвлөгөөг баталж үүнд бусад далайд гарцгүй орнууд болох Казахстан, Узбекистан, Лаос зэрэг улсын түүхий эдийн биржийн туршлага судлах, түүнчлэн олон улсад түүхий эдийн биржүүдэд өргөн ажиглагддаг агуулахын бичгийг Монгол Улсад нэвтрүүлэх эрх зүйн судалгаа хийхээр тусгасан.

Монгол Улсын хувьд хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг экспортлох явцад тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд чанар, стандартын хувьд олон улсын шаардлагад нийцэх хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг сонгон, түүнийг нийлүүлэх улс орныг тодорхойлж, нарийвчилсан зах зээлийн судалгаа хийх зорилго бүхий “Хонины ноосны дотоод болон гадаадын зах зээлийн судалгаа хийх, боловсруулах чиг үүрэг бүхий дотоодын зөвлөх үйлчилгээ авах” ажлын даалгаврыг боловсруулж Экспортыг дэмжих төсөлд хүргүүлэв.

Азийн хөгжлийн банкнаас Монгол Улсад хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл авах, харилцан санал солилцох, цаашид хамтран ажиллах боломжийг эрэлхийлэх зорилгоор хоёр байгууллагын хооронд албан уулзалт зохион байгууллаа.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Монгол Улсад хэрэгжиж буй "Хоршоонд суурилсан хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил төсөл"-тэй уулзалт зохион байгуулж цаашдын хамтын ажиллагааны хүрээнд хийгдэх ажлуудын талаар харилцан санал солилцов.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны бодлогын хүрээнд хийгдэж буй нөөцийн мах бүрдүүлэх ажлын хүрээнд нөөцийн махыг хэрхэн бүрдүүлэх, биржийн оролцоо болон хяналт тавих үйл ажиллагааны талаар санал боловсруулан хүргүүлэв.

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд тавигдах "Хөдөө аж ахуйн биржийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх арга зам" сэдэвт танилцуулгыг бэлтгэв.

Цахим хөдөө аж ахуй зорилтын хүрээнд байгууллагын танилцуулга /брошур/, дижитал гарын авлагыг контент хэлбэрээр баяжуулан оруулав. Уг дижитал гарын авлагад албан ёсны QR код хийж гүйцэтгэн ажилласан. Түүхий эдийг чанар, стандартын дагуу бэлтгэх аргазүйн гарын авлагыг хийж гүйцэтгэв.

Биржээр хүнсний буудай арилжих болсонтой холбогдуулан тариалан эрхлэгчид болон гурилын үйлдвэрүүдэд биржийн арилжаанд хэрхэн оролцох талаар 3 минут 38 секундын видео контентыг "Грийн Тийм Икс" ХХК-тай хамтран бэлтгэж, байгууллагын албан ёсны цахим хуудас, gogo.mn, news.mn, ikon.mn болон салбарын яамны албан ёсны цахим хуудсуудаар дамжуулж олон нийтэд түгээв.

Байгууллагын цахим хуудсыг шинэчлэх ажлын хүрээнд цахим хуудасны UI, UX дизайныг тодорхойлох ажлыг "Прокрафт" ХХК-тай хамтран гүйцэтгэхээр ажиллаж байна.

Биржийн цахим хуудсанд тавигдах хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн зах зээлийн үнэ ханшны мэдээллийг бэлтгэн биржийн цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.




ЗАХИРГАА, УДИРДЛАГА

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Төлөөлөн удирдах зөвлөл

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл 2021 онд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа 6, хараат бус 3, нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллалаа.



а. Төлөөлөн удирдах зөвлөл 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 6 удаа хуралдаж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаас чиглэл, удирдамж авч, 17 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, 6 удаагийн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл, 15 тогтоол гаргасан байна.

б. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд Аудитын, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороод ажиллаж байгаа бөгөөд тус хороодын бүрэлдэхүүнийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн тогтоолоор тус тус шинэчлэн баталлаа.

в. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр Компанийн 2021 оны төсөвт тодотгол оруулахтай холбоотой 3 асуудал, компанийн бүтэц, орон тоо, Гүйцэтгэх захирлыг томилж, чөлөөлөхтэй холбоотой 4 асуудал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаатай холбоотой асуудлууд, Биржийн арилжааны шимтгэлтэй холбоотой асуудал, санхүүтэй холбоотой асуудлууд зэрэг компанийн үйл ажиллагаатай холбоотой нийт 17 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал зохион байгуулах, удирдамж хүсэх албан бичиг, хурлын тов гаргах, холбогдох материалыг бэлтгэх, гишүүдэд цаасан болон цахим хэлбэрээр хуралдааны тов, зар хүргүүлсний дагуу хуралдааныг зохион байгуулж, хурлын тэмдэглэл, тогтоол шийдвэрийн төслийг бэлтгэн албажуулж, шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллалаа.

Санхүү, хөрөнгө оруулалт

Монгол Улсын Засгийн газраас коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авч ажиллах үүднээс тухайн жилийн төсвийн жилд төрийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэн гаргасан 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж, тэвчиж болох зардлуудыг хэмнэхээр зорилтот түвшинд тусган, зардлыг 10 хувиар хэмнэж ажиллах төсвийн тодотголыг компаний Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулан, хэмнэлтийн горим баримтлан үйл ажиллагааны зардлаас хэмнэлт гарган ажилласан.

2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 0 үлдэгдэлтэй байгаа, ашиглалтын хугацаа нь дууссан хөрөнгийг акталж, данснаас хасах зөвлөмжийн дагуу 300 нэр төрлийн 326 сая төгрөгийн хөрөнгийн жагсаалтыг гаргаж компанийн өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, хурлын шийдвэр болон бусад холбогдох материалыг бүрдүүлэн данснаас хасах зөвшөөрөл авах хүсэлтийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн бөгөөд холбогдох зөвшөөрлийг гарсны дараа санхүүгийн бүртгэлд зохих ёсоор тусгахаар бэлдээд байна.

2021 оны хөрөнгө оруулалтын талаарх мэдээлэл

Биржийн арилжааны мэдээг Арилжаа, цахим хөгжүүлэлтийн нэгж болон Төлбөр тооцоо, бүртгэлийн нэгжээс тогтмол цаасаар болон цахимаар авч арилжаа, төлбөр тооцооны шимтгэлийг тооцон брокер компаниудаас цаг хугацаанд нь нэхэмжилж, шимтгэлийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн.

Өмнөх 2019, 2020 оны арилжааны шимтгэлийн өрийн үлдэгдэлтэй байсан брокерын компаниудтай төлбөр барагдуулах талаар хугацаатай мэдэгдэл өгч, шат дараалсан арга хэмжээ авч ажилласны үр дүнд компанийн 400 гаруй сая төгрөгийн өр төлбөрийг 100 хувь барагдуулсан.

Татвар, нийгмийн даатгалын шимтгэл

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2020 онд төвлөрүүлэх байсан 2019 оны ногдол ашиг 543,0 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 2019 оны аж ахуй нэгжийн орлогын албан татвар болон 2020 оны нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг төлж барагдуулсан бөгөөд 2021 оны татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг хуулийн хугацаанд нь төлж татварын өр үүсгэлгүй ажиллаж байна.

Ложистикийн төв, Блокчейн технологид суурилсан арилжаа, төлбөр тооцооны иж бүрэнд системийн бүртгэл

Төв аймгийн Аргалант сумын нутагт байрлалтай компанийн эзэмших зөвшөөрөлтэй 4 га газрыг санхүүгийн бүртгэлд бүртгэх эсэх талаар зөвшөөрөл хүссэн хүсэлтийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн бөгөөд холбогдох зөвшөөрлийг гарсны дараа санхүүгийн бүртгэлд зохих ёсоор тусгахаар бэлдээд байна.

Блокчейн технологид суурилсан “Арилжаа, төлбөр тооцооны иж бүрэн систем”-ийг хүлээн авах ажлын хэсэгтэй хамтран системийн холбогдох өртгийн задаргаа, тайланг гүйцэтгэгч компаниар бэлтгүүлж, санхүүгийн тайланд бүртгэх материалыг бэлдсэн.

Блокчейнд суурилсан арилжаа төлбөр тооцооны иж бүрэн системийг хүлээн авч санхүүгийн бүртгэлд бүртгэх эсэх талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газарт болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн бөгөөд холбогдох зөвшөөрлийг гарсны дараа санхүүгийн бүртгэлд зохих ёсоор тусгахаар бэлдээд байна.

Худалдан авалт, урсгал зардал

Компанийн 2019 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаа болох 1,523,700,0 /Нэг тэрбум таван зуун хорин гурван мянга долоон зуун мянган/ төгрөгийн төсөвт өртөгтэй “Ложистикийн төвийн оффис, агуулахын барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралтыг гүйцэтгэх, тоног төхөөрөмж нийлүүлэх ажил”-ын гэрээний гүйцэтгэлийг гүйцэтгэгч компаниар хангуулах, уг хөрөнгө оруулалтыг компанийн хөрөнгөд хүлээж авах ажлын хэсэг байгуулагдан газар дээр нь ажиллаж, дутуу хийгдсэн ажлыг гүйцээж хийлгэх 35 заалт бүхий хугацаат үүрэг өгч, хяналт тавин ажиллаж 2021 оны 6 дугаар сард багтаан талууд хүлээлцэх актаар ажлыг хүлээн авч, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэхэд шаардлагатай байгаа хөрөнгийн дахин үнэлгээг “Мөнх-Оргил трэйд” компаниар хийлгэсэн.

Компанийн 2021 оны Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 49,0 сая төгрөгийн өртөгтэй “Жишиг сумын ноосны төхөөрөмж худалдан авах” тендерийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийг баримтлан цахим, нээлттэй тендер зохион байгуулж, гэрээ байгуулж ажилласан.

Хөдөө аж ахуйн биржээр хүнсний улаан буудайг дамжуулан худалдах, дериватив зах зээлийн судалгааны ажлын зөвлөх үйлчилгээний нээлттэй тендерийг цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулж, “Бодлогын шийдэл” Төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж ажилласан.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулалт

Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам болон түүнд нийцүүлэн гаргасан хүчин төгөлдөр мөрдөж буй журмуудын хэлэлцүүлэг зохион байгуулах, хэрэгжилтэд дүгнэлт гаргах, шаардлагатай журмын төслийг шинэчлэн боловсруулж, батлуулах ажлыг гүйцэтгэх чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг Гүйцэтгэх захирлын 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн А/73 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна.

Улсын Их хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 43-т Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 2021 оны 5 дугаар сарын 27-ны өдөр нэгжүүдээс санал авч, нэгтгэн боловсруулж Сангийн яаманд хүргүүллээ.

"Мэдээллийн ил тод байдал болон мэдээлэл авах эрхийн тухай" хуулийн төсөлд санал хүргүүлсэн.

Хуулийн хэрэгжилт хяналт

Биржийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Санхүүгийн зохицуулах хороонд тайлан, төлөвлөгөөг хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллалаа.

Хөдөө аж ахуйн салбарт хийгдэж буй "Цахим хөдөө аж ахуй"-г бий болгох зорилтын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Хөдөө аж ахуйн бирж, Мал эмнэлгийн ерөнхий газар хамтран малын түүхий эдийн чанар, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, малын гаралтай түүхий эдийн зөв зохистой бэлтгэлийг бий болгох, анхан шатны тордолт, чанарын хамгаалалт хийх, мөшгөх тогтолцоог бий болгох зорилгоор хариуцсан аймгийн сумдуудад мэдээлэл хүргүүлж, хариуцсан аймгийн сумдуудад үйл ажиллагаа явуулж байгаа агуулахтай холбоотой мэдээлэл солилцон ажилласан.

Биржийн дотоод дүрэм, журам боловсруулах сайжруулах ажил



Хэнтий аймгийн Баян-овоо суманд зохион байгуулагдсан загвар хоршооны танилцуулгад Хоршооны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн танилцуулга, биржийн үйл ажиллагаатай холбогдуулан таниулах танилцуулгыг боловсруулав. Хоршооны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн давуу тал болон үзэл баримтлалыг тодруулж, хоршооны техник эдийн засгийн үндэслэлд хавсралтаар оруулав.

Энэхүү ажлын хүрээнд Хоршооны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийг баримтлан Хоршооны үлгэрчилсэн дүрмийг боловсруулав.

Хөдөлмөрийн хууль шинэчлэн батлагдаж 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр болсонтой холбогдуулан компанийн “Хүний нөөцийн боддлогын барим бичиг”, “Ажлын төлөвлөлт, тайлагнал, түүнд хяналт тавих журам”, “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн батлуулахаар төслөөр бэлдсэн.

Тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар хүн амыг эх орны үйлдвэрийн эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр тогтвортой хангах зорилгоор улаанбуудайн тариалан эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал болон мөнгөн бус дэмжлэг үзүүлэх, бусад бүтээгдэхүүнд мөнгөн бус дэмжлэг үзүүлэхэд зориулсан хөрөнгийг зарцуулах, тайлагнах, хяналт тавихтай холбоотойгоор үүсэх харилцааг энэхүү журамд саналаа хүргүүлсэн.

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас Тариалангийн үйлдвэрлэл эрхлэж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгө урамшуулал олгох мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журмыг шинэчлэн боловсруулах төсөлд санхүүгийн эрсдэл талаас санал хүргүүлсэн.



Гэрээ хэлэлцээр, санамж бичиг

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагатай байгуулах хамтран ажиллах баримт бичгийн төслийг боловсруулах, гарын үсэг үзэглэх арга хэмжээг зохион байгуулах, хамтын ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллав. Энэ ажлын хүрээнд 2021 онд дараах хамтран ажиллах санамж бичиг болон гэрээг байгуулав.

Үүнд:

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд заасны дагуу арилжааны 4 гэрээ буюу шууд арилжих гэрээ /spot/, хугацаат гэрээ /форвард/, нэг загварын гэрээ /фьючерс/, ирээдүйд худалдах, худалдан авах гэрээ /опцион/-г байгуулна гэж хуульчилсан байдаг. Өнөөдрийн байдлаар “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-д арилжааны своп болон форвард гэрээг түлхүү ашиглаж байна.

Захиргаа, байгууллагын дотоод үйл ажиллагааны хүрээнд ажилтнуудтай Хөдөлмөрийн гэрээ, Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ, Нууцын гэрээ болон Хөлсөөр ажиллах гэрээг байгуулж ажиллаж байна.

2021 оны эхний хагас жилийн хүрээнд дараах төрлийн гэрээг байгуулсан байна



Гэрээний төрөл	Байгуулагдсан гэрээний тоо
Агуулахын итгэмжлэл олгох гэрээ	106
Ажил гүйцэтгэх гэрээ	11
Зээлийн гэрээ	1
Лабораторийн итгэмжлэлийн гэрээ	11
Нууц хадгалах, хамгаалах гэрээ	5
Сургалтын гэрээ	1
Түрээсийн гэрээ	7
Хамтран ажиллах гэрээ	5
Хөлсөөр ажиллах гэрээ	10
Худалдах, худалдан авах гэрээ	3

Цаашид “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль”-д заасны дагуу 4 төрлийн гэрээг биржид байгуулах хууль, эрх зүйн орчинг судлах, боломжийг бүрдүүлэх, спот болон форвард гэрээг засан сайжруулах, фьючерс болон опцион гэрээний загварыг боловсруулж биржид арилжихад шаардлагатай эрх зүйн орчинг судлаж байна.

Хөдөө аж ахуйн биржээр Хүнсний улаан буудайг дамжуулан худалдах, дериватив зах зээлийн судалгааны ажлын зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичиг боловсруулах, хянах, зохион байгуулах, гэрээ байгуулах, ажил хүлээлцэх актын төсөл боловсруулж ажиллав.

Цар тахлын эсрэг хэрэгжүүлсэн ажил

Дархлаажуулалт

Ажилтнуудын нийгмийн хамгааллын ажлын хүрээнд байгууллагын бүх ажилчдыг “Сөүл” эмнэлэгт урьдчилан сэргийлэх иж бүрэн багцын шинжилгээнд хамруулан, Ковид-19 цар тахлаас сэргийлэх, дархлаажуулалтыг дэмжих амин дэм, эмийн багц олгосон.

Мөн ажлын хүрээнд Компанийн байранд ирж ажиллаж байгаа ажилтнуудын халууныг өдөр бүр шалгаж, сэжигтэй тохиолдолд асуумж бөглүүлэн тэмдэглэл үйлдэж, нийт ажилтнуудад сэжигтэй шинж тэмдэг илэрсэн, Коронавируст халдвараар өвчилсөн хүнтэй ойрын хавьталд орсон тохиолдолд заавал шинжилгээ хийлгэж байж ажлын байранд ирэх талаар зарлан мэдээлж, “Сос медикал” эмнэлгээс 2 удаа эмч урьж Ковид19 цар тахлыг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээ хийлгэхэд шинжилгээ өгсөн нийт ажилтны шинжилгээний хариу сөрөг гарсан.

Ковид-19 цар тахлын хариу арга хэмжээний хүрээнд Нийслэлийн эрүүл мэндийн газар, Нийслэлийн Онцгой комисст хүлээлгэн өгч буй Sonata 7 маркийн 0840 УБҮ улсын дугаартай автомашиныг цагийн хуваарийн дагуу эрүүл мэндийн төвүүд, мөн хэрэгцээ шаардлагатай байгаа газрууд, гэрээр тусгаарлагдаж буй өвчтөнүүдэд тусламж үйлчилгээ үзүүлэх үйлчилгээнд явуулах зорилгоор байгууллагын ажилчдаас мөн “Хөлсөөр ажиллах гэрээ”-г иргэн Н.Лхагвасүрэн, Ч.Хатанболд нартай байгуулан 2021 оны 6 дугаар сарын 19-ний өдрөөс мөн оны 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэл Хан-Уул дүүргийн 5 дугаар хорооны “Мандал Үйлс” өрхийн эмнэлгийн үйлчилгээнд явуулав.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдаас ирүүлсэн чиглэлийн дагуу Коронавируст халдварын эсрэг 3 дахь тунгаар вакцинжуулах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд одоогийн байдлаар тус компанийн 27 ажилтан 3 дахь тун вакциндаа хамрагдаад байна. Вакцин хийлгээгүй байгаа ажилтнууд 100 хувь 2 тун вакцинд хамрагдсан бөгөөд Коронавируст халдвараар өвчлөөд эдгэсэн хугацаа, мэргэжлийн эмчээс өгсөн зааврын дагуу вакцинаа хугацаанд хийлгэхээр төлөвлөн ажиллаж байна.

Хөл хорио

Коронавируст халдвар, цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх үүднээс Засгийн газар, Улсын Онцгой комисс, Нийслэлийн Онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилтийг ханган Компанийн дэд захирлаар ахлуулсан Шуурхай штабын бүрэлдэхүүнийг байгуулж, зарим ажилтнуудыг тодорхой хугацаагаар гэрээс нь цахимаар ажиллуулах, зарим тохиолдолд хуваарьт оруулан ээлжээр ажиллуулах зэрэг Гүйцэтгэх захирлын тушаалаар зохицуулалт хийж шаардагдах төсөв зардлыг тусгаж ажилласан.

Бусад мэдээлэл

Монгол Улсын Засгийн газраас коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авч ажиллах үүднээс тухайн жилийн төсвийн жилд төрийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэн гаргасан 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд шинээр тавилга, эд хөрөнгийн худалдан авалт хийгээгүй, тогтоолын хэрэгжилтийг ханган ажилласан.

Компанийн албан хэрэгцээнд шаардлагатай ариутгалын бодис 24 ширхэг, ариутгагч спирт 36 ширхэг, халуун хэмжигч багаж 1 ширхэг, 1 удаагийн амны хаалт /mask/ 2000 ширхэг, ариутгалын мананцар үүсгэгч, цэвэрлэгээний багаж хэрэгсэл зэрэг эд зүйлсийг тухай бүрт нь авч өдөр бүр өрөө тасалгаанд чийгтэй цэвэрлэгээ хийж, 14 хоногт нэг удаа зориулалтын мананцар үүсгэгчээр өрөө тасалгааг ариутган ажиллаж байна.

Аудит

2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас санхүүгийн тайлангийн баталгаажуулалтын аудит хийгдэж “Зөрчилгүй дүгнэлт” авсан.

Үндэсний аудитын газар болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газраас ирүүлсэн 2020 оны аудитын шалгалтаар өгсөн зөвлөмжийн биелэлтийн тайланг бэлтгэн хүргүүлсэн.

Үндэсний аудитын газрын 2021 оны ээлжит санхүүгийн тайлангийн аудитын шалгалтад шаардлагатай байгаа материалууд болон тайлан, журналуудыг бэлтгэн аудитын байгууллагад хүргүүлсэн.




Хүний нөөц

Нийт ажилтан албан хаагчдын мэдээлэл

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 06 дугаар тогтоолоор компанийн зохион байгуулалтын бүтцийг Гүйцэтгэх захирал 1, Дэд захирал 2 болон 5 нэгж, нийт 43 орон тоотойгоор баталсан.

Компанийн нийт ажилтны хүний нөөцийн хувийн хэргүүдийг цэгцэлж, дутуу баримтуудын бүрдлийг хангаж, Гүйцэтгэх захирлын 2013 оноос хойшхи Б тушаалуудыг хуулбарлан ажилтнуудыг хувийн хэрэгт баяжилт хийсэн.



Нийт ажилтнуудаас санал авч 2021 оны ээлжийн амралтын хуваарийг боловсруулж Гүйцэтгэх захирлын 2021 оны А/06 дугаар тушаалаар батлуулж, хуваарийн дагуу ээлжийн амралтыг олгосон.

Компанийн 30 албан тушаал /ажлын байр/-ын тодорхойлолтыг шинэчлэн төслөөр боловсруулж нэгжүүдээс саналыг авч нэгтгэн Гүйцэтгэх захирлын 2021 оны А/15 дугаар тушаалаар батлуулж тус тусын ажилтнуудад танилцуулсан.

Компанид олон жил үр бүтээлтэй ажилласан 6 ажилтныг Төрийн дээд шагналаар шагнуулахаар тодорхойлж, 2021 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар шагнагдсан.



Томилсон чөлөөлсөн шийдвэрийн талаар товч

Хүний нөөцийн томилгоо, ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх, эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой 80 орчим тушаалын төсөл боловсруулж батлууллаа.

Компанийн эрх бүхий албан тушаалтнууд болох Гүйцэтгэх захирал, дэд захирлууд, нэгжийн менежерүүд, ерөнхий нягтлан бодогч, ТУЗ-ийн хараат бус гишүүд болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд бүртгэж, тайлагнав.

Бизнес хөгжлийн нэгжийн Ахлах мэргэжилтэн, Судалгаа шинжилгээний мэргэжилтэн, Захиргаа, удирдлагын нэгжийн Захирлын туслах, Архив, бичиг хэргийн эрхлэгч, Жолоочийн сул орон тоонд нээлтэй сонгон шалгаруулалт явуулж ажилтан сонгож авах тухай зарын дагуу ирүүлсэн 1200 хүний анкет, материалуудыг Гүйцэтгэх захиралд танилцуулж, сонгон шалгаруулалт явуулж сул орон тоог нөхсөн.

Сахилга хариуцлага цаг ашиглалт

Тайлангийн хугацаанд 9 ажилтанд сахилгын шийтгэл ногдуулсанаас 8 ажилтанд сануулах, 1 ажилтанд ажлаас халах сахилгын шийтгэлийг ногдуулсан.

Зөрчлийн хэлбэрээр авч үзвэл шалтгаангүйгээр ажил тасалсан 3, ажлын байрны тодорхойлолтод заасан ажлыг хангалтгүй биелүүлсэн 3, Гүйцэтгэх захирлын өгсөн үүргийг хугацаанд нь зохих ёсоор гүйцэтгээгүй 2, шууд удирдах албан тушаалтны зөвшөөрөлгүй ажлын дундуур гарч ажлын байрны дэг журам зөрчсөн 1 зөрчил гаргасан байна.

Байгууллагын ажилтан, албан хаагчдын ажлын ирц бүртгэлийн байдалд 4 удаа хяналт хийж ажил тасалсан, хоцорсон ажилтны бүртгэлийг гаргаж удирдлагад танилцуулсан.

Нийгмийн асуудал

Сургалт

Компанийн нийт ажилтныг чадавхижуулах, ажлын байран дахь ур чадварыг дээшлүүлэх, ажлыг хурдан шуурхай гүйцэтгэхэд чиглэсэн “2021-2022 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөө”-г боловсруулан батлуулж 11 төрлийн сургалтад давхардсан тоогоор 78 ажилтныг суралцуулсан.

Авилгатай тэмцэх газраас 2021 оны 5 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор төрөөс санхүүжилт олгох үйл ажиллагаанд нээлттэй, ил тод, шударга байдлыг хангах нь” сургалтад компанийн 30 ажилтныг цахимаар хамрууллаа. Мөн тус газраас 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр цахимаар зохион байгуулсан сургалтад компанийн 22 ажилтныг хамруулав.

Компанийн засаглалын хөгжлийн төвөөс 2021 оны 11 дүгээр сарын 19, 20-ны өдрүүдэд зохион байгуулсан Компанийн засаглалын сургалтад 2 албан тушаалтныг хамруулж сертификат авсан.

Монголын Хуульчдын холбооноос зохион байгуулдаг хуульчдын үргэлжилсэн 3 багц цагийн сургалтад компанийн 3 хуульч цахимаар хамрагдлаа.

“Худалдан авах ажиллагааны боловсрол төв” төрийн бус байгууллагаас 2021 оны 6 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд цахимаар зохион байгуулсан “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх А-3 эрх олгох” сургалтад компанийн 15 ажилтныг бүртгүүлж, сургалтад оролцуулав.

“Фушяа Сафир” компанитай хамтран ажилтны чадавх, ажлын байран дахь мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн “Arc GIS” програмын газар зүйн мэдээллийн систем ашиглах сургалтад компанийн 4 ажилтныг хамруулж сургалтыг амжилттай зохион байгуулж гэрчилгээ авсан.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Элчин сайдын яамнаас 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулсан “Хөдөө аж ахуйг хөгжүүлэх нь” сэдэвт сургалтад компанийн 7 ажилтан цахимаар оролцож, гэрчилгээ авсан.

Сангийн яамнаас 2021 оны 10 дугаар 13-ны өдрийн 14 цагт зохион байгуулсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа”, “Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн танилцуулга” сэдэвт цахим сургалтад компанийн 8 ажилтныг хамруулав.

Олон улсын Мэргэжлийн боловсролын хүрээлэнтэй хамтран 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс 10 дугаар сарын 29-ний хооронд зохион байгуулагдсан “Дунд шатны менежерийн удирдан зохион байгуулах, манлайлах ур чадварыг дээшлүүлэх” сэдэвт сургалтад компанийн 10 удирдах ажилтныг хамруулж, гэрчилгээ авсан.

Мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны хооронд зохион байгуулсан тасралтгүй боловсролын сургалтад компанийн Ерөнхий нягтлан бодогч, Нягтлан бодогч нар цахимаар оролцсон.

ЖАЙКА-Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын Монгол улсын хөдөө аж ахуйн салбарын нэмүү өртгийн сүлжээний мастер төлөвлөгөө боловсруулах төслөөс 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс 12 дугаар сарын 01-ний хооронд зохион байгуулсан хамтран ажиллагч, байгууллагуудын ажилтнуудад зориулсан “Япон Улсын Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний түгээлт нийлүүлэлт болон үйлдвэрлэлийн кластерийн хөгжил” сэдэвт сургалтад компанийн 4 ажилтныг хамруулав.

Мэргэжлийн боловсролын академийн Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын талаар Олон улсын сертификат олгох цахим сургалтад 1 ажилтан хамрагдсан.

Хөдөлмөрийн хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан компанийн нийт ажилтнуудад Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэл, өөрчлөлт орсон зүйл заалтын талаар 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр сургалт орохоор төлөвлөсөн.

Ажилтны төлөөлөл

Гүйцэтгэх захирлын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/85 дугаар тушаалаар компанийн нийт ажилтны санал асуулгыг үндэслэн 6 хүний бүрэлдэхүүн бүхий ажилтны төлөөлөгчдийг баталсан.

Архив албан хэрэг хөтлөлт

Компанийн үйл ажиллагаатай холбоотой Гүйцэтгэх захирлын 164 тушаал, 389 албан бичгийн төсөл боловсруулж, компанид ирүүлсэн 199 албан бичигт хариу хүргүүлж ажиллав.

Цахим архивын сан бий болгох ажлын хүрээнд 2013-2020 оны Гүйцэтгэх захирлын А, Б тушаал 6000 гаруй хуудас баримтыг скайнардан PDF файл болгон цахимжуулсан.

Байнга хадгалах хадгаламжийн нэгж 179, 70 жил хадгалах хадгаламжийн нэгж 46, 15 жил хадгалах хадгаламжийн нэгж 249, 10 жил хадгалах хадгаламжийн нэгж 335, 1-5 жил хадгалах хадгаламжийн нэгж 341 нийт 1150 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна. “Хадгаламжийн нэгж бүрдүүлэх заавар журам”-ийн дагуу хийгдээгүй буюу биримт бичгийн нүүр бичилт хийгдээгүй 150 гаруй хадгаламжийн нэгжид нүүр бичилт хийсэн. “Архивт баримт хүлээлгэж өгөх заавар”-ийн дагуу хадгаламжийн нэгж болгон бүрдүүлээгүй 2013-2020 оны материалуудыг үдэж цэгцлэн хавтаслаж 239 ширхэг хадгаламжийн нэгж болгон бүрдүүлсэн.

Хувьцаа эзэмшигчийн хурал

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 6-д заасны дагуу Компанийн төрийн мэдлийн хувьцаа эзэмшигч болох Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь өөрийн эрх хэмжээний хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлд компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар чиглэл, удирдамж өгч ажиллаж байна. Үүний дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хэлэлцсэн асуудал, гаргасан тогтоол шийдвэрийн талаар хувьцаа эзэмшигчид тайлагнаж байна.

Мөн Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4-т заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулахаар бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна.

Олон нийтийг хамарсан арга

ХЭМЖЭЭ

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд компанийн ажилтнууд 2021 оны 10 дугаар сарын 07-ны өдөр Налайх дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт мод тарих үйл ажиллагаанд идэвхитэй хамрагдсан.

Компанийн биеийн тамир, спортын хамтлагаас 2021 оны 12 дугаар сарын 03-ний өдрөөс 05-ны хооронд шатар, ширээний теннис, дартс, гар бөмбөг, сагсан бөмбөгийн спортын 5 төрөлт тэмцээн зохион байгуулж компанийн ажилтнууд идэвхитэй оролцсон.

Гүйцэтгэх захирлаас өгсөн чиглэлийн дагуу 2021 оны 8 дугаар сарын 20-ны өдрөөс 9 дүгээр сарын 03-ны өдрийн хооронд нийт ажилтнаас "Биржийн үйл ажиллагааг сайжруулах" саналыг авч нэгтгэн Гүйцэтгэх удирдлагын багт танилцуулж, компанийн 2022-2026 онд хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн төлөвлөгөөнд тусгалаа.

Компаниас 2021 оны 08 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан Ложистикийн төвтэй компанийн ажилтнуудыг танилцуулах, санал солилцох арга хэмжээнд нийт ажилтнууд идэвхитэй оролцсон.

Компанийн ажилтнуудын ажлыг хагас жил, жилийн эцсээр дүгнэж хагас жилийн ажлын үр дүнгээр эрхэлсэн ажилдаа хариуцлагатай хандаж, бодит үр дүн гаргасан зарим ажилтныг урамшуулсан.

Ажлын хэсэг, үнэлгээний хороонд ажилласан байдал

Гүйцэтгэх захирлын тушаалаар 33 ажлын хэсэг, 1 үнэлгээний хороо байгуулагдан ажилласан. Ажлын хэсэг, үнэлгээний хороодын ажлын явц байдалд хяналт шинжилгээ хийж Гүйцэтгэх захиралд танилцуулсан

Томилолтоор ажилласан байдал

Тайлангийн хугацаанд 11 удаагийн дотоод томилолтоор давхардсан тоогоор компанийн 75 ажилтан, орон нутагт томилолтоор ажиллаж, ажлын үр дүн, тайланг тухай бүр Гүйцэтгэх захиралд танилцуулсан.



ДҮГНЭЛТ



ДҮГНЭЛТ

1. “Хөдөө аж ахуйн бирж” ХХК 2021 онд өөрийн ТУЗ-ийн баталсан төлөвлөгөөний дагуу үндсэн чиглэлийн таван нэгж, 43 ажилтны бүрэлдэхүүнтэй ажиллалаа. 2021 онд цар тахлын хүчин зүйлээс шалтгаалан эхний таван сард нийт ажилтны 30 хувь нь ажлын байранд ирж ажиллаж, үлдсэн 70 хувь нь үндсэн цалингийн 60 хувиар цалинжин гэрээр ажилласан ч цаг үеийн ажлууд хэвийн явагдаж байлаа.

2. 2021 онд Бирж нь 2022-2026 оны дунд хугацааны стратегээ тодорхойлж ТУЗ-өөр батлуулсан. Үүнд томоохон зорилтууд нь олон улсын жишигт нийцсэн бирж болох, спот арилжааг идэвхижүүлэх, хуулинд заасан үүсмэл санхүүгийн хэрэгслийг нэвтрүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, оролцогчдын тоо, арилжааны хэмжээг нэмэгдүүлэх, итгэмлэлийн үйл ажиллагааг тодорхой болгох зэрэг олон ажлыг шат дараатай хэрэгжүүлэхээр тусгасан.

3. 2021 онд Бирж хүнсний буудайг арилжих бэлтгэлийг бүрэн хангаж ажилласан бөгөөд энэ удаад тариаланчдаас гарсан саналын дагуу Засгийн газраас арилжааг урдны журмаар явуулах чиглэл өгч уг ажил хойшиллоо. Харин 2022 онд Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 4.5, 5.1.7-д жагсаалтад орсон бараа, түүхий эдийг төсвийн хөрөнгөөр худалдан авах бол биржээр дамжуулна гэж заасны дагуу улаан буудайн арилжааг Биржээр дамжуулж, цаашид хэвшүүлэх шаардлагатай байна. Ингэснээр бүртгэл, чанар, ложистик, санхүүжилтийн асуудал богино дунд хугацаанд жигдрэн, олон улсын жишгийн дагуу хэрэгжих нөхцөл бүрдэнэ.



4. Цахим хөгжүүлэлтийн хүрээн арилжаа, төлбөр тооцооны блокчейн програмыг сайжруулах нэмэлт 113 ажлын даалгавар боловсруулан гүйцэтгэгчийн зүгээс хөгжүүлэлтийг хийж тус програмыг бүрэн хүлээн авч нэвтрүүлсэн. Мөн програм шинэчилсэнтэй холбогдуулан хэрэглэгч агуулах, лаборатори, брокеруудад шат дараалсан сургалтыг өгсөн. 2022 онд програмыг банктэй холбох, биржийн дотоод гар ажиллагааг цахимжуулах, үүсмэл санхүүгийн хэрэгсэл арилжаалах бэлтгэл ажлууд хийгдэнэ.

5. 2021 онд Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг боловсруулах, үүнд үүсмэл санхүүгийн хэрэгслийн тухай дэлгэрэнгүй оруулах, дэд бүтцийн байгууллагуудыг итгэмжлэх асуудлыг олон улсын практикт нийцүүлэн тусгах, түүхий эдийн бирж хөгжсөн бусад улсад малчид, тариаланч, үйлдвэрлэгчдийн санхүүжилтийн хэрэгсэл болгон өргөнөөр ашигладаг агуулахын бичиг, түүний зохицуулалт, эрсдлийн удирдлагын асуудал зэргийг тусган ажиллаж байна. Эдгээр асуудлаар туршлага судлахаар олон улсын биржүүдтэй цахим сургалт, мэдээлэл авах, газар дээр нь туршлага судлах зайлшгүй шаардлагатай байна.



ХААБ
ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ

2021

